

## **ДЖИТАЛ ЭРИНИЙ УЛС ТӨРИЙН КОММУНИКАЦИ**<sup>18</sup>

**Томас Шевори** доктор

АНУ, Итака коллеж, Улс төрийн шинжлэх ухааны тэнхим

**Түлхүүр үгс:** коммуникаци, суртал ухуулга, улс төрийн сурталчилгаа, аналог мэдээллийн хэрэгсэл, хүний эрх, хүрээлэн буй орчин, сонгуулийн сурталчилгаа

Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд улс төрийн коммуникацид жинтэй өөрчлөлт орсон ч түүний тодорхой бүрдэлүүд хэвээр үлдсэн. Энэ удаад тэдгээр өөрчлөлтийн заримаас дурдахын зэрэгцээ тэдгээрийн үзүүлж буй нөлөөг ч хөндөн авч үзье гэж бодлоо. Энэхүү өгүүллийн гол зорилго нь улс төрийн коммуникаци дахь өөрчлөлт, түүний логик уялдааны талаархи концептуаль хүрээг тодорхойлж хувьсал өөрчлөлтийг нь тодорхой жишээн дээр дэлгэн харуулах болно.

Улс төрийн коммуникаци гэдгийг энгийнээр “улс төрийн зорилгын үүднээс харилцах чадвар” гэж тодорхойлж болно. Зарим нэгэн жич асуудлыг эс тооцон, ХХ зууны улс төрийн коммуникацийг задлан шинжилвээс бүхэлдээ төвөөс хязгаар руу, дээрээс доош чиглэсэн мэдээллийн урсгал маягтай байв. Үүний хоёр сонгодог жишээ бол суртал нэвтрүүлэг ба корпораци болон улс төрийн сурталчилгаа юм. Эдгээрийн (нийтлэг тал нь) үзэгч, сонсогчдыг гэнэн, хувирамтгай тул улс төрийн мессеж өгөх замаар тодорхой хэв маягаар сэтгэх, үйлдэхэд хүргэж болно хэмээн үздэгт байгаа юм.

### **Төвлөрсөн коммуникаци: Хорьдугаар зуун**

Адольф Гитлерийг хорьдугаар зууны хамгийн нэрд гарсан улс төрийн суртал нэвтрүүлэгчдийн тоонд зүй ёсоор тооцдог. Найруулагч Лени Райфеншталийн дэлгэцийн бүтээлүүд, ялангуяа түүний “Хүсэл зоригийн Ялалт” бүтээл нь Германы ард түмнийг Нацист Намыг дэмжихэд уриалсан, түүгээр ч зогсохгүй дайнд хүргэсэн бүтээл болж чадсан. Тоталитари (хүчирхийллийн) нийгмийн үед суртал ухуулга нь коммуникацын гол зэвсэг болдгыг Нацизмын жишээ тодорхой харуулж байна. Гэвч авторитари (захиргаадгалтын) дэглэм ганцаараа суртал ухуулгыг мобилизаци хийх үр дүнтэй арга болгон ашигладаг юм бишээ.

Ерөнхийлөгч Рузвельтийн засаг захиргаа ч дэлхийн хоёрдугаар дайнд Америкийн ард түмний дэмжлэгийг дайчлахын тулд суртал нэвтрүүлгийг ашиглаж байсан. Тухайн үеийн Цэргийн Яам “Ноён Смит Вашингтон руу явсан нь”, “Гайхамшигт амьдрал” зэрэг олон сонгодог бүтээлийн найруулагч Франк

<sup>18</sup> МУИС-ийн Улстөр судлалын тэнхмийн багш Д.Ундрахын орчуулснаар нийтлэв.

Капраг “Бид юуны төлөө тулалдав?” нэртэй дайны тухай хамгийн хурц шийдэлтэй, гайхалтай үр дүнтэй болж чадсан суртал ухуулгын киног бүтээлгэхээр хөлслөн авч байв. Энэхүү бүтээлдээ найруулагч Капра гэрэлтэй ба сүүдэртэй, өөрөөр хэлбэл, ардчилсан эрх чөлөөт ба дарангуйллын дэглэмт хоёр ертөнцийг гаргасан. Америкийн түүхэн дэх хамгийн хөдөлшгүй түүхэн баримт, бэлгэ тэмдгийн тоонд зүй ёсоор тооцогдох Тусгаар Тогтнолын Тунхаг бичиг, Линкольны Дурсгалын Хөшөө зэрэгт түшиглэн найруулагч Капра дайн гарах бодит нөхцөл нь Сувдан эрэг боомт руу хийсэн довтолгоон ч бус, харин сайн ба муугийн хоорондын тэмцэл байсан хэмээн харуулахыг зорьжээ.

Рузвельтийн засаг захиргаа дайны үед ч суртал ухуулгад тавих анхаарлаа сулруулаагүйн дээр, түүний дэвшүүлсэн “Шинэ чиглэлийн бодлого” ч тухайн үедээ олон баримтат киноны сэдэв болж байсан бөгөөд зорилго нь хямралд автсан эдийн засгийн тогтолцооны үед ард түмний итгэл найдварыг сэргээх явдал байв. Харин үүнд Ардчилсан Намыг улс орныг аврах хариуцлагатай хүчин болгон харуулж байлаа. Ийнхүү “Шинэ чиглэлийн бодлого”-ын ололт амжилтыг магтан дуулах, суваг далан босгохоос эхлээд хөрс хамгаалах зэрэг олон ажлыг гардан гүйцэтгэж байсан Иргэний Хамгаалах Корпусын үйл ажиллагааны тухай олон арван кинонууд хийгдэж байв.

Дурдагдсан олон хүчин чармайлтуудыг “суртал нэвтрүүлэг” хэмээн тодорхойлсноор тэдгээрийн ач холбогдлыг бууруулсан хэрэг огт үгүй бөгөөд харин бодит баримтыг л тодорхойлж байгаа хэрэг. Дэлхийн II дайнд АНУ татагдан орсон нь ёс суртахууны шаардлагаас үүдэлтэй бөгөөд “Шинэ чиглэлийн бодлого” Америкийн нийгэм, эдийн засгийн бодлогод хийсэн чухал эргэлтийн шав болсон юм. Бүхэлд нь дүгнэвэл, улс төрийн коммуникацийн тодорхой хэв маягийг дүрсэлж байгааг энд дурдаж байна. Эдгээрийг хооронд нь холбож буй зүйл бол олон нийтийн санаа бодолд нөлөөлөх, төрийн бодлогыг дэмжихийг зоригжуулах төр засгийн удирдагчдын хүсэл эрмэлзэл юм.

Коммуникацийн нэгэн хэв маяг болохынхоо хувьд суртал ухуулга нь олон түмний хүрээгээр хязгаарлагдаж байсангүй. Компани корпорацийн эсвэл улс төрийн кампанит ажлын зар сурталчилгааны аль аль нь суртал нэвтрүүлгийн нэг л хэлбэр билээ. Зар сурталчилгааны манипуляци хийх зорилго, үр нөлөөний талаар олонтаа бичигдэж байсан тул энд нарийвчлан дурдахыг зориогүй бөгөөд дэлхийн капиталист амьдралыг түгээн дэлгэрүүлэх хэрэгсэл нь зар сурталчилгаа болж байна гэж хэлэхэд л хангалттай болов уу. Бидний амьдралд хаа сайгүй нэвчин орсоноор зар сурталчилгаа нь юу уух, хувцасаа яаж угаах, ямар тамхи татахыг (эсвэл ерөөсөө бүр тамхи татах эсэх) зэрэг зүйл бүрийн шийдвэрийг гаргахад маань хүртэл нөлөөлж байна.

Зар сурталчилгаа нь орчин үеийн хүний ухамсарт хүртэл нөлөөлж байна. Ардчилсан нийгмийн гишүүд нь эдүгээ эхлээд хэрэглэгч, дараа нь иргэн гэдэг байр сууринаас харагдах боллоо. Зар сурталчилгааны талаархи хамгийн эхний бөгөөд нэлээд жинтэй шүүмжлэгч нь Герберт Маркузе юм. “Нэг хэмжээст хүн” хэмээх түүний зохиолд хорьдугаар зууны дунд үеийн капиталист нийгмийн иргэд

хэрхэн зар сурталчилгааны хатуу дайралт дор хэрэглэгчийн нийгмийн үл сэтгэгчид болж байгаа тухай өөрийн таамаглалыг дэвшүүлсэн байдаг. Ийм үнэлэлт дүгнэлт гаргасан нь ганц тэр биш бөгөөд тэрээр корпорацийн суртал ухуулгын хамгийн хөнөөлтэй хэлбэр хэмээн зар сурталчилгааг үзсэн социологич Торштейн Веблений гаргасан шүүмжлэлийн мөрөөр замнасан билээ.

Тэгэхээр, энд би зар сурталчилгааны талаар өөр ямар нэгэн шүүмж хэлэхийг зориогүй бөгөөд ердөө л хорьдугаар зууны олон нийтийн коммуникацийн гол хэлбэрийн нэг болох улс төрийн суртал ухуулгатай холбогдож байгаа болохыг нь тэмдэглэн хэлэхийг хүсч байна. Энэ нь мөн дээрээс доош чиглэх мэдээллийн урсгалыг харуулж байна. Корпорацийн зар сурталчилгааны ажилтанууд санал солилцох, ярилцах талаар улс төрчдөөс ч дор байдаг. Зах зээл дээр зөвлөгөө өгөх, хариу шүүмж хэлэх ардчилсан механизм гэж үгүй. (гэвч зохицуулалтын зарим аргыг ардчилсан үйл явц санал болгож болдог).

Мэдээжийн хэрэг, улс төрийн сурталчилгаа нь улс төрийн коммуникаци өөрөө шатлан захирах замаар хүрдэг, сонгогчдын үйл байдалд нөлөөлдөг гэсэн үзэл баримтлалыг тусгахын зэрэгцээ батжуулж байдаг. Хорьдугаар зууны Америкийн сонгуулийн кампанит ажлын хамгийн муу сөрөг сурталчилгаанд тооцогдох “Дейзи”-ээс Вилли Хортон хүртэлх сурталчилгааны материалуудаас харахад улс төрийн кампанит ажлын менежерүүд Америкийн сонгогчдын сэтгэл хөдлөлд ихэнхдээ тэдний хамгийн хар дарсан айдсаар нь дамжуулан нөлөөлж болно гэж үздэгийг нь харуулдаг. Сонгуулийн кампанит ажлыг зохион байгуулагчид энэ маягаар сонгуулийн үр дүнд нөлөөлж болно гэдэгтээ итгэдэг ажээ.

Хорьдугаар зууны улс төрийн коммуникаци нь ихэнхдээ нэг урсгалтай үйл явц байсан хэдий ч, бүхэлд нь мөн ингэж дүгнэж болохгүй юм. Ардчилсан тогтолцоонд сонгогчид нь улс төрийн сурталчилгаа, суртал ухуулгын нөлөөнд ордог ч бие даан сонголт хийдэг ба тэдгээрээс бүхэлдээ хамаараад байдаггүй. Ерөнхийлөгч Рузвельт дайны үйл явц болон Шинэ чиглэлийн бодлогын тухайд маш үр дүнтэй олон нийтийн дэмжлэгийг дайчилж чадсан хэдий ч, энэ нь түүнийг шилдэг суртал ухуулагч байсан гэдгээр зөвхөн тодорхойлогдохгүй. Шинэ (эргэлтийн) бодлого нь ажлын байр, тэтгэвэр тэтгэмж, эдийн засгийн хамгаалалтын өөр олон хэлбэрүүд зэрэг бодит, үр өгөөжтэй саналуудыг дэвшүүлж байсантай холбоотой. Цаашлаад, авторитари дэглэм ч дор хаяж нийгэм дотор оршиж буй янз бүрийн ашиг сонирхол, олон нийтийн санаа бодолд ямар нэг хэмжээгээр анхаардаг байх хэрэгтэй гэдэг дээр улс төр судлаачид удаан хугацааны турш маргалдаж ирсэн бөгөөд эс бөгөөс тэд эрх мэдлийг өөрсдийн гарт төвлөрүүлж чадахгүйд хүрнэ гэж үздэг.

Ноам Чомскийн “Үйлдвэрлэх зөвшөөрөл” бүтээлд, Америкийн сэтгүүлзүй (бүхэлдээ) суртал нэвтрүүлгийн үйлд оролцдог гэжээ. АНУ нь ардчилсан орон хэмээгддэг ч, олон нийтийн мэдээллийн байгууллагууд нь үндсэндээ төрийн удирдлагын үзэл суртлын шаардлагыг хүлээн зөвшөөрсөөр ирсэн. Америкийн

сэтгүүлзүйд голлох үзэл суртлын номлолд дурамжхан хандах явдал багахан хэмжээгээр л илэрч байжээ. Чомский Америкийн гадаад бодлогыг тусгайлан сонирхож үзээд Америкийн сэтгүүлчид тэр байтугай “либерал” гэгдэх хэсэг нь ч, АНУ-аас Вьетнам, Камбож, улмаар Никарагуа болон Эль Сальвадор зэрэг Латин Америкийн орнуудад явуулсан цэргийн интервенцийн асуудалд дэмжигч байр сууринаас хандаж ирсэн гэдгийг тогтоосон байдаг.

Түгээмэл соёлын онолчид хэрэглэгчид (хувцас, телевизийн түгээмэл суваг, эсвэл бүр шүдний оог хэрэглэгчид ч бай ялгаагүй) нь янз бүрийн мэдээллийн эх сурвалжаас авдаг мэдээллийг идэвхигүйгээр хүлээн зөвшөөрдөг ердөө нэг хоосон савнууд биш гэдэг санааг дэвшүүлдэг. Хэрэглэгчийн соёл дотор хүртэл консюмеризмын<sup>19</sup> эсрэг санал, байр сууриуд ажиглагддаг. Энэ нь корпорацийн зар сурталчилгаа хамгийн өргөн тархсан бөгөөд боловсруулалтын дээд төвшинд хүрсэн гэгддэг АНУ-д ч байдаг билээ.

Түгээмэл соёлын онолчид хэрэглээний ертөнц нь үйлдвэрлэгчид, зар сурталчилгааны байгууллага болон хэрэглэгчдийн хоорондох нарийн төвөгтэй хэлэлцээ дээр суурилдаг гэж үздэг. Эхнийх (үйлдвэрлэгч, сурталчилгааны байгууллагууд) нь өөрсдийн бүтээгдхүүнийг худалдан авах, хэрэглэхийг хүсдэг бол, удаах (хэрэглэгч) нь бараа бүтээгдхүүний зэрэгцээ өөрсдийн бие даасан, хараат бус байдлыг хадгалах, бүтээлч байхыг хүсдэг. Өөрөөр хэлбэл, хэрэглэгчид нь манипуляцид өртөгсөд болж болохын зэрэгцээ бас ч гэж бүхэлдээ түүний нөлөөнд автаад байдаггүй.

Өөрийн гэсэн хэв загвар, хөгжим, тэр ч байтугай өвөрмөц хэлийг хүртэл бий болгосон залуусын соёлд хэрэглэгч нийгмийн шаардлагатай холбоотой эсэргүүцэл олонтаа тохиолдох ба нийгмийн хэм хэмжээнд дурамжхан ханддаг. Өөрөөр хэлбэл, нийгэм дэх улс төрийн эсэргүүцэл, сэтгэл дундуур байдлын далд суурь нь нийгмийн бүх давхаргын микро хэсэгт буюу ялангуяа залуучуудын дунд элбэг байдаг.

Гэвч хэрэглэгчид хэр зэрэг бие даасан байх вэ, тэдний эсэргүүцэл ямархан хэмжээгээр илэрч болох вэ гэдэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн зохион байгуулагдсанаас шууд хамааралтай. Корпорацийн болон улс төрийн мессеж хувь хүний бодол санаанд хэр гүнзгий хүрч байна вэ гэдэг асуулт түүний төвлөрсөн бүтэцээр тодорхойлогдоно. Корпорацийн болон улс төрийн хяналтыг дурамжхан хүлээн авах явдал нь коммуникацийн төвлөрсөн хэлбэрийн хариу үйлдэл гэж харагдана. Үүнгүйгээр байж болохгүй юм. Тухайлбал, Ю.Хабермасын дэвшүүлсэнээр, төвлөрлийг дээд зэргээр сааруулсан, нээлттэй нийгэмд л улс төрийн болон корпорацийн удирдлагыг эсэргүүцсэн улс төрийн эсэргүүцэл байдаггүй бөгөөд шаардлагагүй юм гэж үзжээ.

Коммуникацийн тодорхой технологиуд болон түүнийг тойрсон институтууд улс төрийн коммуникацийн төвлөрөлд нөлөөлдөг. Маршалл МакКлунны

---

<sup>19</sup> худалдах, худалдан авах гэдэг нь нийгэм, хувь хүний хувьд хамгийн чухал үйл ажиллагаа гэж үзэх үзэл. -орч

тодорхойлсоноор арга хэрэгсэл нь мессеж байж болох ч, (коммуникацийн) хэрэгсэл нь энгийн нэгэн технологийн үр дүн бишээ. Телевиз, радио, кино театр, утсан холбоо эсвэл бүр понограм бичлэг зэрэг нь тэрхүү институциональ контекстийн дотор оршино. Хэвлэл мэдээлийн хэрэгсэл нь нийгэм, эдийн засгийн амьдралд нөлөөлдөгийн зэрэгцээ өөрөө мөн тэдгээрийн нөлөөнд оршиж байдаг.

Томхон бюрократ аппарат нь коммуникацийн төвлөрлийг дэмждэг. Рузвельтын засаг захиргаанаас бүтээсэн суртал ухуулгын кинонууд хүний болон хөрөнгийн нөөцийг дайчилж, хөдөлгөж болох юм гэдгийг харуулсанаараа онцлог. Бүх л түүхийнхээ туршид, кино бүтээх гэдэг кино зохиол бичих, дуран авайгаар авах, хальс боловсруулах, дуу авиаг хослуулах зэрэг олон тооны чадварлаг хүмүүсийн баг ажиллахыг шаарддаг, хөрөнгийн эрчимтэй үйлдвэрлэл байсаар ирсэн. Эдгээр нөөцийг атгасан байгууллага л зөвхөн олон тооны хүмүүст, үр дүнтэй хүргэх улс төрийн мессежийг бий болгож чадна. Тийм байгууллагын тоонд үндэсний засгийн газар, томоохон корпорациуд, мөн мэдээжийн хэрэг, Голливуд багтана.

Төвлөрсөн коммуникацийн тогтолцоонд хэрэглэгддэг технологи нь үндсэндээ аналог систем дээр үндэслэж байв. Аналог мэдээллийг бүтээх ба түгээх ажил нь олон чухал нөөцтэй байхыг шаарддаг.

Аналог мэдээллийн хэрэгсэл нь дуу болон дүрсийг мэдэгдэхүйц бодитойгоор шууд дамжуулна. 35 миллиметрийн хальсан дээр нимгэн целюлойд ялтасаар дамжуулан гэрэл тусгаснаар хальсан дээр дүрс тодрон үзэгдэнэ. Дэлгэц дээрх дүрс гэдэг нь ердөө л тэдгээр гэрэл, сүүдрийн өсгөсөн хэлбэр юм. Фонограмийн хувьд, дуун долгионыг дискэнд эргэлт үүсгэн суулгаж өгснөөр хөгжим буюу дууг бүтээдэг. Дуун долгионыг өсгөгчөөр дамжуулан сонсогчид хүргэнэ. Анхны фонограмуудын дуу өсгөгчөөр энгийн чанга яригчыг ашиглаж байлаа. Аажмаар томоохон хэмжээний, өртөг өндөр стерео системийг бүтээснээр бичсэн дууг өсгөх, өөрчлөх боломжтой болов. Кино бүтээх болон дуу авиаг өсгөвөрлөх нарийн төвөгтэй үйлдвэрлэл хувьсан хөгжиж буй хэдий ч тэдгээрийн үндсэн элементүүд үндсэндээ аналог систем дээр суурилсан хэвээр байна.

Хорьдугаар зууны мэдээллийн салбарт аналог мэдээлэл давамгайлсаар байлаа. Дуу, дүрсийг дахин боловсруулах гайхалтай боломж, өмнөх үеийн мэдээллийн хэрэгсэл (дардсан үсэг бүхий хэвлэл)-ийг давсан томоохон дэвшил мөн боловч аналог үйлдвэрлэл нь хэрэглээ болон түгээлт борлуулалтын хувьд харин ч өндөр өртөгтэйн дээр, тодорхой бэрхшээлтэй. 35 миллиметрийн хальс бүхий хайрцагыг тээвэрлэж явах гэдэг өртөг ихтэй, нүсэр хүнд ажил болдог. Хатуу пластик (пянзны) бичлэгүүд нь олон тоогоор авч явах үед бүр ч хүнд ачаа юм. Кино хальс нь гэмтэж, шатаж болохоос гадна хамгийн болгоомжтой хандсан ч зурагдах нь энүүхэн. Цаг хугацааны саалтанд энэ нь муудсаар байдаг. Хуванцар пянзууд хялбар зурагдахын зэрэгцээ олон удаагын хэрэглээнээс болж бичлэгний зураасууд нь гэмтэж эхлэнэ. Эх бичлэгээс нь хувилах гэдэг

бэрхшээлтэйн дээр, мөн л үнэ өртөг нь хямд тусахгүй. Энэ мэт сул талыг нь эс тооцвол, аналог систем нь олон хүний хувьд дуу дүрсийг нямбайлан буулгаж болох мэдээллийн шилдэг хэлбэрт тооцогдсоор байна. Хорьдугаар зуунд бүтээгдсэн гайхамшигт дуу, дүрсний цуглуулгууд нь хүн төрөлхтөний гоозүйн аугаа амжилт, авьяас билгийг илтгэн харуулсаар байгаа билээ.

Одоог хүртэл эдгээр төрлийн үйлдвэрлэлийн хөрөнгө санхүүгийн гайхалтай өсөлт, хязгаарлагдмал түгээлт, дахин боловсруулалтын хүндрэл бүгд нийлэн улс төрийн коммуникацийн төвлөрсөн тогтолцоог хөхүүлэн дэмжихэд хүргэсээр иржээ.

### **Дижитал мэдээллийн хэрэгслийн мандалт**

Дижитал электрон мэдээллийн хэрэгсэл нь тоон буюу дижитал мэдээллийг хадгалах, дамжуулах, хүлээн авах үүрэгтэй. Дижитал мэдээллийн хэрэгсэл нь өөрөөр хэлбэл, компьютер ашиглан мэдээллийг боловсруулж, дамжуулдаг хэрэгсэл юм. Хорьдугаар зуун аналог мэдээллийн хэрэгсэлийг зөгнөсөн бол, хорин нэгдүгээр зуун дижитал (тоон) мэдээллийн хэрэгсэлийн зуун болж байна.

Дижитал мэдээллийн хэрэгсэл нь үйлдвэрлэл, түгээлтийн бүх хэлбэрийг диск болон МП 3-ыг форматлахаас эхлээд мэдээллийг түгээх интернет, компьютерийн програм хангамж хүртэл бүгдийг багтаана. Аналог болон дижитал мэдээллийн хэрэгслийн хооронд зарчмын ялгаа бий. Аналог мэдээллийн хэрэгсэл нь мэдээллийг шууд хувилсаных (фото зургийн ялтас, кино, пьанз) нь дараа дамжуулдаг бол, дижитал мэдээллийн хэрэгсэл нь хүлээн авсан мэдээллийг компьютерийн мэдээллийн нэгж (1-0) болгон эвдэж түүнийг компьютерийн програмаар дамжуулан дахин бүтээдэг байна. Өөрөөр хэлбэл, дижитал мэдээлэл гэдэг нь компьютерийн механик болон электрон эд анги таних боломжтой, нарийн төвөгтэй програмыг ашиглан боловсруулсан тоон тогтолцоо юм.

Хэдийгээр дижитал мэдээллийн хэрэгсэл нь дуу авиа болон дүрсийн хувьд аналог мэдээллийн хэрэгслийн адил гоозүйн хувьд сэтгэл ханамжтай хүлээн авахуйц чанартай байж чаддаггүй тухай шүүмж гардаг хэдий ч, олонхи хэрэглэгчдийн хувьд үйлдвэрлэл болон хэрэглээний хялбар тал олгодог тул материалын чанар нь чухал бус хэмээн үзэхэд хүргэдэг ажээ. Аналог эрин хэрэглэгчдийн хувьд заримдаа бичлэгийн чанарт сэтгэл зовниход хүргэж, хэн нэг нь хэдэн мянган долларыг төлөн сонгодог болон нийтийн дууны шилдэг бүтээлүүдийг хамгийн сайн, хамгийн цэвэр тунгалаг хуулбарлах өртөг ихтэй стерео системийг худалдан авах хэрэгтэй болдог байсан бол, дижитал эринд хэрэглэгчид чанар муу, ихэвчлэн их гэмтэж гажуудсан дуу авиатай хөгжмийг “iPod”-ынхоо чихэвчээр сонсч байна.

Аналог мэдээллийн эринд, хэрэглэгчид асар том кино танхимд, заримдаа бүр амьд хөгжимтэйгээр (дуугүй киноны үед) кино үзэж, томоохон хэмжээний

дүрс, дуу нь үзэгчдийг бүрэн эзэмддэг байсан бол, харин өнөөдөр хэрэглэгчид нь галт тэрэг, тэр ч байтугай өөрсдийн автомашинд явж байхдаа видео дүрсийг өөрсдийн “iPhone”-ын бяцхан дэлгэц дээр төвөггүйхэн буулган авдаг болжээ.

Аль ч тохиолдолд, дуу, дүрсний чанар нь ашиглах боломжийн хажууд төдийлөн чухал биш болжээ. Өнөөдөр хэдэн мянган киног Нетфликс мэтийн арилжааны олон сайтуудаас тэр ч байтугай манай гаригийг хэрсэн олон зуун сайтуудаас хууль бусаар татаад авах ч боломжтой болсон. Хялбар дөт байдал, уян хатан чанар болон хэрэглээ нь хэрэглэгчдийг тогтмол биш, үйлдвэрлэгчид нь хэдийн хяналтаа алдсан тоо томшгүй олон дүрс, хэлбэрүүд рүү татаж байна. Дуу дүрсэд дураараа нөлөөлөх буюу өөрчлөх боломжтой боллоо.

Дижитал коммуникаци руу шилжсэн эдийн засгийн үр дагавар ч итгэмээргүй үзүүлэлт дагуулсан. 1960-70-аад оны Америкийн ихэнх хотуудад түгээмэл тохиолдох дуу бичлэгийн дэлгүүрүүд нь жижиглэн худалдаанд компакт диск гарах болсоноор 1990-ээд он гарахад үгүй болов. Бичлэгийн томоохон компаниуд аажмаар шахагдаж, жижиг студиуд, улмаар хөгжимчид өөрсдийн бүтээлийг хянах боломжтой болов. Боломжийн чанартай бичлэгийг ердийн зөөврийн компьютер ашиглан хийх болсон нь дуу бичлэгийн томоохон студиудыг мөхөлд хүргэж эхлэв.

Кино урлагийн салбарт ч ийм шилжилт бас явагдсан. Хэдийгээр Голливуд томхон хэмжээний, өртөг ихтэй “Аватар” мэтийн уран бүтээл дээр ажилласаар байгаа боловч хямд төсөр, биед хөнгөн дижитал видео камертай хэн бугай ч боломжийн кино бүтээж болох болжээ. Бүтээгдхүүний чанрын хувьд эдгээр бүтээлүүд Голливудтай өрсөлдөхгүй нь тодорхой ч, YouTube сайт дахь “Өөрсдөө хийгээд үз” булангаар агшин зуурт өөрийн хүссэн зүйлийг бүтээж алдарших боломж бий болов.

Дижитал мэдээллийн хэрэгслийн түгээлтийн хялбар тал магад үүнд онцгой нөлөөлсөн. Хууль бусаар татах, суулгах боломж нь олон дуу бичлэгийн компаниудын ашиг орлогод сөргөөр нөлөөлсний дотор Голливуд ч багтдаг. Өөрөөр хэлбэл, дижитал мэдээллийн хэрэгслээс коммуникацийн төвлөрсөн хэлбэрт чиглэсэн аюул занал олон талтай, ээдрээтэй, байнгын хувьсамтгай болсноос хянах боломж үндсэндээ үгүй болжээ. Түгээлтийн хялбар тал нь бэрхшээлтэй асуудал (зохиогчийн эрх гм.) дагуулахын зэрэгцээ давуу тал ч олгосоныг хэлэх нь зүйтэй. Одоо хэрэглэгчдээс хэн бугай нь ч маш чадварлаг уран бүтээлч, тэрчлэн мэдээллийн түгээгч болох боломж нээгджээ:

Дижитал мэдээллийн хэрэгсэлд шилжсэн шилжилтийн эдийн засгийн үр дагавар ноцтой хэдий ч, түүний улстөрийн үр дагаврын талаар цохон дурдахыг хүсч байна. Хорьдугаар зуунд эдийн засаг болон улс төрийн эрх мэдэлтэнгүүд (улс төрчид, төрийн албан хаагчид, хувийн корпорациуд) үндсэндээ хаа сайгүй аналог мэдээллийн бүтээлийг хянах боломжтой байсан бол, хорин нэгдүгээр зууны дижитал мэдээллийн хэрэгсэл нь олон талаараа илүү ардчилсан шинжтэй болжээ. Бид бүхэн хүссэн мэдээллээ бэлтгэн хаа сайгүй түгээх боломжтой

даяаршсан ертөнцийн иргэд болсон. Ийнхүү олон хүмүүст мэдээллийг бэлтгэхийн зэрэгцээ түгээх боломж нөөц бий болсноор улс төр, эдийн засгийн эрх мэдлийг атгагчдын засаглалыг “эвдэх” бололцоо үүсч байна. ***Дижитал мэдээллийн хэрэгсэл нь улс төрийн засаглалыг эсэргүүцэх эсэргүүцлийг бий болгож улс төрийн өөрчлөлтөд хүргэх талтай.***

Гэхдээ энэ нь дижитал мэдээллийн хэрэгсэл бүхэлдээ ардчилсан, эсвэл сул талгүй гэсэн үг огтхон ч биш юм. Энэ нь хувийн асуудалд эрсдэл дагуулахын зэрэгцээ хянаж чадахгүй ч түүнд нөлөөлж бүрэн чадах эдийн засгийн институцийн бүхэл бүтэн шинэ тогтолцоог бий болгож эхэлсний жишээ бол Майкрософт, Facebook болон Google г.м. юм.

Энэхүү санаагаа тодруулахын тулд дижитал мэдээллийн хэрэгслийг ашиглан хэрхэн засаглалын зохион байгуулалттай бүтцийг өөрчлөхөд хүргэж болох талаар урьд өмнө бол огт боломжгүй байсан зарим нэгэн жишээг доорхи асуудлуудын хүрээнд авч үзье. Үүнд:

- 1) Хүрээлэн буй орчны хамгаалалт
- 2) Хүний эрх
- 3) Улс төрийн зар сурталчилгаа

### **Хүрээлэн буй орчны асуудал:**

Америк төдийгүй дэлхий даяар хүрээлэн буй орчны асуудлаар олон түмний зохион байгуулалттай үйл ажиллагаа анхаарлын төвд байсаар ирлээ. Дэлхийн өдрийг тэмдэглэх санаачилга нь хүрээлэн буй орчны талаархи олон түмний бодлогод шууд нөлөөлсөн. Дэлхий даяар хэдэн сая хүн 1971 оны 4 сарын 21 өдөр зохион байгуулагдсан Дэлхийн Өдөрт оролцсон гэдэг. “Дэлхийн өдөр”-ийн концепци нь дэлхийн эко-системийг хамгаалах талаар өөрсдийн санаа бодол, дуу хоолойг хуваалцах гэсэн олон нийтийг нэгтгэхэд чиглэсэн байв. Гэвч энэ бол ердөө эхлэл. 1980-аад онд байгаль орчныг хамгаалах хөдөлгөөний үйл ажиллагаа ид оргилдоо хүрч байх үед Америкт төдийгүй хаа сайгүй хүмүүс бусдын анхаарлыг байгаль орчны доройтолд хандуулахын тулд биеэ хүртэл золиослож байлаа. Уг хөдөлгөөний идэвхитнүүд баруун Америкийн цэвэр ойн сүүлчийн нөөцийг огтлуулахгүйн тулд модон дээр, эсвэл бульдозерын хошуун дээр суун тэмцэж байв.

1990-ээд онд байгалийн шүүх хөдөлгөөнийхөн дэлхийн химийн бохирдолын асуудлыг хөндөн мөн л хорт хог хаягдал, тэдгээрийг шатаах зуухыг хаахын тулд өөрсдийн бие махбодоор дэнчин тавин тэмцэж байлаа. АНУ-д болсон үйл явдлуудаас хамгаас их олны анхаарал татсан нь дэлхийн хамгийн том хорт хаягдал шатаах зууханд тооцогдож байсан Баруун Виржиния муж дах шатаах зуухны үйл ажиллагааг зогсоохоор хэдэн мянган дэмжигчид татагдан орсон явдал байв.

Гэхдээ хүрээлэн буй орчноо хамгаалах асуудал зөвхөн АНУ-аар хязгаарлагдаагүй юм. Энэтхэгийн байгаль хамгаалах хөдөлгөөний олон талт,



нарийн төвөгтэй үйл ажиллагааны талаар Вандана Шива баримтжуулан үлдээсэн бол, “Чипко” хэмээх эмэгтэй голдуу гишүүдтэй ой хамгаалагчид олон үндэстний хөдөө аж ахуйн бүтээгдхүүн үйлдвэрлэлд зориулан огтолсоор байсан Энэтхэгийн ой шугуйг хамгаалах үйлсэд амжилт гаргаж чадсан юм. Кенийн ойг хамгаалах, нөхөн сэргээх үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн Вангари Маатхай Нобелийн шагнал хүртсэн нь түүний олон жилийн нөр хөдөлмөрийн дүнд Кенийн засгийн газрыг уриалан, өөрийн амьдарч буй эх байгальд аюул учруулж байгаа экологийн өөрчлөлтийн хор хохирлыг гүнзгий ухамсарласан олон тооны (дийлэнхи олонхи нь эмэгтэйчүүд) гишүүд дэмжигчдийн дэмжлэг туслалцаатайгаар авч явуулсан арга хэмжээнийх нь үр дүн байв.

Дижитал эринд цахим хөдөлгөөний шинэ хэлбэр үүсэн бий болж байна. *Суперфонд 365* нь Нью Йорк хотноо үүсгэн байгуулагдсан бие даасан, урлаг/мэдээллийн хөтөлбөрийн төсөл юм. Энэхүү интернет сайт нь АНУ даяар Суперфонд нэрийн дор явагдах үйл ажиллагааны талаар мэдээлдэг. Суперфонд гэдэг нь засгийн газар зэрэг байгууллагаас албан ёсоор химийн хорт хаягдал, хог бохирдолтой болохыг нь зарласан газрууд юм. Онолын хувьд Америкийн Байгаль Хамгаалах Агентлагаас албан ёсоор хог хаягдал, бохирдол бүхий цэгүүдийг Суперфондын газар хэмээн зарлаад, улсын хөрөнгөөр (Суперфондод хуримталсан хөрөнгө) тэдгээрийг цэвэрлэх асуудлыг шийдвэрлэх ёстой. Гэвч Америк орон даяар хэдэн зуун ийм цэг байдаг ба цэвэрлэгээний ажилд зарцуулах хөрөнгө ч их болох нь ойлгомжтой. Хамгийн их хөдөлгөөнтэй, юунаас ч хоцордоггүй хүмүүс хүртэл ихэвчлэн өөрсдийн амьдардаг хот ч юм уу, ойр хавьдаа байгаа Суперфондод бүртгэгдсэн газруудыг мэддэггүй. (Тухайлбал, миний төрсөн хот болох Нью Йорк мужийн Итака хотод дөрвөн ч ийм газар байдгын дээр, бүр миний амьдардаг байшингийн ойролцоо хүртэл бий.)

Суперфонд 365 нь Суперфондын бүртгэлтэй хог хаягдал, химийн бохирдолтой цэгүүдэд олны анхаарлыг хандуулан орон нутгийн оршин суугчдад мэдээлэх, олон нийтийг цэвэрлэгээний ажилд уриалах зорилготой дижитал мэдээллийн төсөл юм. Энэ нь олон нийтийн зохион байгуулалтыг дижитал мэдээллийн хэрэгсэлтэй холбож буй хэрэг. Суперфонд 365 нь холбогдох хот дүүрэг, хөршийн холбоодын идэвхтэн гишүүдтэй хамтран хууль зөрчигч байгууллагуудын (хувийн хэвшил болон төрийн агентлагууд ч байх нь бий) талаар болон бий болсон химийн бохирлын хэлбэр, төрлийн талаар мэдээлэл цуглуулах ажлыг хийнэ. Тэрчлэн мэдээлэл, материалын тэгш бус хуваарилалтыг (ихэвчлэн арьс өнгө, угсаатны цөөнхи орших ядуу дүүргүүд багтдаг) тогтоох үүднээс хүн амзүйн судалгаа явуулна. Энэхүү вебсайт мөн цэвэрлэгээний ажлын явц болон фото зурагт баримтуудыг багтаадаг. Эхний жилдээ, уг вебсайт бохирдол, хог хаягдалтай цэгүүдийг бараг л өдөрт нэгийг зарлаж байв.

Суперфонд 365 нь урьд өмнө огт байгаагүй байгаль хамгаалах ажлын шинэ хэлбэр байв. Энэ нь өмнөх хэлбэрийг орлож байгаа бус харин ч химийн

бохирдлын талаар мэдээллийг олж авах нөхцөлийг боломжийн хэмжээнд нэмэгдүүлж өгсөн явдал юм. Орон нутаг дах нөхөрлөлийн гишүүдийг өөрсдийн амьдардаг хот, дүүрэг дэх химийн бодисын талаархи мэдээллээр хангаж, мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгосноор бусад иргэд энэ мэт бэрхшээлтэй асуудлын талаар мэдэх ухаарах боломжтой болж байна. Хамгийн гол нь, уг сайт удаан хугацаанд үргэлжилж буй байгаль орчны ужиг асуудлуудыг шийдвэрлэх холбооны улсын хуулинд заасан үүргээ биелүүлэхийг Байгаль Хамгаалах Агентлагт (АБХА) шаардах, шахалт үзүүлэхэд чиглүүлэх олон нийтийн үйл ажиллагаанд дэмжлэг болж, иргэдийг мэдээллээр хангаж байгаа юм. АБХА-ын үйл ажиллагааны талаархи иргэдийн хардлага сэжгийн талаар бусад идэвхитэн гишүүдтэй холбогдох, цаашлаад мэдээллээр хангах, боломжит үйл ажиллагаанд бодитойгоор татагдан оролцоход түлхэц үзүүлэх зорилгоор төрийн удирдах албаны хүмүүстэй харилцах хүртэл арга хэмжээг санал болгодог байна.

### **Хүний эрхийн асуудал:**

Америк дах хүний эрхийн хөдөлгөөний сонгодог жишээнд Иргэний Эрхийн Хөдөлгөөнийг тооцдог. Энэ нь умард, өмнөдийнхний улс төрийн эрх тэрчлэн Америкийн улстөрийн системийн үндсэн институцуудын үйл ажиллагааг сорьсон ардын хөдөлгөөн байв. Телевиз Иргэний Эрхийн Хөдөлгөөнийг амжилтад хүрэхэд онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн. Уг хөдөлгөөний удирдагчдын нэг Мартин Лютер Кинг улс төрийн коммуникацийн жинхэнэ мастер байв. Америкийн түүхэнд үлдэх олон алдартай илтгэлийг тавьсан, чадварлаг уран илтгэгч тэрээр 1963 оны зун Вашингтон Моллд өөрийн алдарт “Миний мөрөөдөл” илтгэлээ тавьж байв. Гэвч Кингийн хүчирхэг илтгэлийн цаана уг хөдөлгөөнийг дэмжигчид болон эсэргүүцэгчдийн бүрдүүлэх хүчирхэг дүр төрх бас байсан.

Кинг умардын улс төрчид, улмаар умардад оршин суугч цагаан арьстануудын дэмжлэг чухал гэдгийг ухаарч байлаа. Иймээс ч тэрээр, нэгэнтээ цохон тэмдэглэж байсанчлан “цагаан арьстануудын ухамсар”-т хүрэхийг оролдож, Өмнөд мужууд дах арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдлуудыг гэрчлэх хүчирхийллийн дүр зургууд умардын цагаан арьстнуудын тусламж дэмжлэгийг авахад амин чухал гэдэгт итгэж байлаа. Тус хөдөлгөөний цар хүрээ зөвхөн Мартин Лютер Кингийн удирдан зохион байгуулсан үйл ажиллагаагаар хязгаарлагдаагүй. Орон нутагт нийтийн тээврийн автобусанд арьс өнгөөр ялгаварлахын эсрэг зохион байгуулсан Эрх чөлөөний маршрут, мөн фото зураг, кино хальсанд буулгаж баримтжуулсан Умард Каролина мужийн коллежийн оюутнуудын суулт зэрэг олон алхмуудыг зоригтой санаачлан явуулж байлаа. Арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг эсэргүүцсэн жагсаалд оролцож буй дунд сургуулийн сурагчид руу цагдаагийн ноход дайрч, гал унтраах шахуургаар жагсагчид руу ус шүршиж буй цагдаагынхны дүр зураг Америкчууд төдийгүй даян дэлхийг цочирдоход хүргэж байв. Мартин Лютер Кинг болон Өмнөдийн Христийн Удирдах Хурал эдгээр үйл ажиллагаануудаараа олны анхаарал,

дэмжлэгийг үлэмж татаж байсан ч, Америкийн өмнөд ба умардын мужуудаар хаа сайгүй тархай бутархай, саланги хүчнүүд оршсоор байв. Энэ утгаараа Иргэний Эрхийн Хөдөлгөөнийг хамгийн их төвлөрсөн бөгөөд бас задралтай, хүчтэй зохион байгуулалттай атлаа дээд зэргийн сарнилтай байсан гэж дүгнэж болох байна.

Хорин нэгдүгээр зуунд дижитал мэдээллийн хэрэгслийг дэлхийн хүний эрхийн болон иргэний эрхийн хөдөлгөөний үйл ажиллагааг илүү өргөн хүрээнд түгээх үйлсэд үр дүнтэй ашиглаж байна. Хэрэв хорьдугаар зууны хүний эрхийн хөдөлгөөн Америкийн Иргэний Эрхийн Хөдөлгөөн эсвэл Өмнөд Африкийн Апартейдын эсрэг Хөдөлгөөний адил нийтлэг шинжтэй байсан бол, өнөөдрийн дэлхий ертөнцөд захын иргэн хүний эрх зөрчсөн аливаа үйлдлийг газар дээрээс нь шууд илчлэх боломжтой болжээ. Нэгэн цагт үл үзэгдэм байсан хүчирхийллүүд эдүгээ даяаршсан мэдээллийн тогтолцооны үрээр илэрхий болов. Ийнхүү хүчирхийллийг нийтэд илчилснээр улс төрийн засаглалын зүгээс хариу өгөх, бодит үйлдэл хийхэд хүргэж, асуудлыг заримдаа нааштайгаар шийдвэрлэдэг бол, заримдаа эсрэгээр болох нь ч бий.

2001 онд байгуулагдсанаасаа хойш интернетийн **‘Гэрч’ (The Witness)** вебсайт нь хүний эрхийн тухай баримтат киноны бүхэл бүтэн сан хөмрөгтэй болсон. Интернет сайтын энэхүү төслийг анх “Генезис” рок хамтлагийн гишүүн Питер Габриэл санаачилан санхүүжүүлж эхлүүлсэн бөгөөд тэрээр уран бүтээлчийнхээ хувьд төдийгүй Африк дах хүний эрхийн асуудалд гүнзгий татагдан орсноороо хэдийн олны танил болжээ.

“Гэрч” сайтын уриа: “Үүнийг хар. Хальсанд буулга. Тэгээд өөрчил”. Эхэндээ энэ сайт хүний эрх ба хүрээлэн буй орчны асуудлаар дэлхийн өнцөг булан бүрээс видео бичлэгийг хүлээн авч цуглуулдаг байв. Өөрийн гэх тодорхой хэрэгсэл үгүй тул онцгой асуудалд анхаарлаа хандуулахын тулд янз бүрийн олон нийтийн байгууллагуудтай хамтран ажилладаг ажээ. Сүүлийн үед уг вебсайтад тавигдсан бичлэгүүдээс дурдвал: Бразилийн хөдөө дэх боолчлол, Ардчилсан Конгын Бүгд Найрамдах Улс дах хүүхэд-цэргүүд, Болгар дах Румын үндэстэн хүүхдүүдийн боловсрох эрх, Калифорнийн хүүхдийн шорон дахь хүчирхийлэл зэрэг болно.

Энэхүү вебсайт нь зөвхөн өөрийн хамтын ажиллагаа болон нэвтрүүлж буй бичлэгийн чанараараа төдийгүй, тухайн асуудлаархи судалгаа, түүнтэй уялдуулан авч явуулах дараагийн үйл ажиллагаараа ялгарч чаддаг байв. Тус вебсайт нь хүний эрхийг зөрчиж буй үйл явдлыг хамгийн халуун цэгээс нь шууд дамжуулан үзүүлэхийг чармайдаг. “Гэрч” дэлхийн өнцөг булан бүрт хүрдэг бөгөөд Дорнод Европ, Өмнөд Африк, Ойрхи Дорнод ба АНУ-аас материал ирдэг. Үүнийг тодорхой хэсэг бүлэг эрх баригчдын баг санаачлаагүй бөгөөд харин киноны уран бүтээлчид болон хүний эрхийн төлөө тэмцэгч идэвхтэн гишүүдийн олон улс дах харилцаа холбоогоороо дамжуулан бүтээдэг юм.

Эхэндээ “Гэрч” сайт нь баримтат киноны уламжлалт хэлбэр болох 20-30 минутад үргэлжилж, оршил ба хүний эрхийг зөрчиж буй тодорхой хэргийн баримтыг дэлгэн харуулсан хэсгээс бүрддэг байв. Гэвч цаг хугацаа улирахын хэрээр түүний нэвтрүүлгийн бодлогод ч өөрчлөлт орж 2005 онд “Бул” (The Hub) хэмээгдэх шинэ сайтыг нээсэн нь хүний эрхийн талаархи дижитал мэдээллийг шинэ төвшинд гаргасан.

“Бул” вебсайт нь байршил тодруулагчаар идэвхжүүлсэн дэлхийн газрын зургийг дэлгэн харуулах бөгөөд идэвхижүүлэгч дээр дарахад л тодорхой бүс нутаг дах хүний эрхийн зөрчлийн талаархи баримтжуулсан материалыг олж харах болно. Харин тодорхой бүс нутгийг сонгон авч товчлуураа дарахад үзэгч бодит видео бичлэгийг шууд үзэхийн дээр мөн болсон үйл явдлын талаар илүү нарийвчилсан тайлбарыг олж үзэх, холбогдох материалуудыг авч болох холболтын шугмыг зааж өгнө. Нэг үгээр хэлбэл, энэхүү шинэ сайт нь хамтын ажиллагааг дээд зэргээр дэмждэг гэж ойлгож болох бөгөөд ердийн гар утсаныхаа камерыг ашиглан хэн ч болов хүний эрхийн асуудлаар идэвхитэй тэмцэгч болж чадна.

Мэдээжийн хэрэг, “Бул” болон түүнтэй адил төстэй бусад вебсайтууд ч ёсзүйн сонирхолтой асуултуудыг дэвшүүлэн тавьдаг. Вебсайтад байршуулсан материалыг хянах, сайтын удирдлагын зүгээс хянан засварлах ёстой юу? Тухайлбал, олон нийтэд илчлэн харуулсанаараа уг бичлэгийг үйлдсэн хувь хүнд аюул заналхийлж болохыг үгүйсгэх аргагүй юм. Мөн зарим материал нь хүчирхийллийн талаар хирдхийлгэсэн дүрс бүхий, маш тодорхой бичлэгийг ч багтаасан байж болно. Сайтын зүгээс иймэрхүү ноцтой үйл явдал, баримтын талаар анхааралтай хандаж, болгоомжлох зааварчилгааг өгдөг боловч хянан засварлах явдал маш бага гэж хэлж болно.

Мэдээжийн хэрэг, “Гэрч” зэрэг вебсайтууд нь олон тооны материалыг хялбар хайлтын системтэй сайтад нэг дор байшуулснаар улс төрийн болон корпорацын эрх баригчдын үйл ажиллагаанд нөлөөлөхөд онцгой ач холбогдолтой болж байна. Мөн тэд онцгой сайн судалгааны материалтайн дээр тус сайтын ажилтанууд өөрийн хамтран ажиллагч түншүүдийнхээ улс төрийн идэвхитэй үйл ажиллагааг нь дэмжин байнгын холбоотой байдаг.

Үүнээс гадна, аль нэгэн байгууллагын хүрээгээр хязгаарлагддаггүй дижитал мэдээллийг түгээх өөр бусад хэлбэрүүд ч хэзээний бий болжээ. Сүүлийн жилүүдэд тэдгээрийн ач холбогдол онцгой өсөн нэмэгдэж байгаа тул тэдгээрээс ердөө хоёрхон жишээг энд авч үзье.

#### Жишээ 1.

Оакланд Калифорнийн метроны буудлын төмөр замын тавцан дээр Оскар Грантийн амь насыг цагдаагийнхан буудан хороосон хэрэг 2009 оны шинэ жилийн анхны өдөр болжээ. Оскар Грант, өөр хоёр залуугын хамт цагдаагийн албан хаагчидтай тулгаран тулалдсанаас цагдаагийн албан хаагч Оскарыг

буудан амь насыг нь хөнөөсөн байна. Үйл явдлыг хэд хэдэн хүн гар утасныхаа камераар бичиж авсан байсан нь хэргийг олон өнцгөөс харах боломжийг олгожээ. Буудалцаанд хүргэсэн шалтгаан юу байсан нь одоо хүртэл тодорхойгүй үлдсэн ч, болсон үйл явдлыг харин хэзээ ч няцаашгүй баримтжуулан үлдээжээ. Цагдаагийн албан хаагч гар хоосон, тухайн мөчид газарт хэвтэж байсан хар арьст залууг буудан амь насыг нь хөнөөсөн байна.

Хэргийн газарт хийгдсэн нэг бичлэгийг YouTube сайтад тавьж, нөгөөг нь Сан Францискогийн орон нутгийн нэгэн телевизийн сувгаар шөнийн мэдээллийн хөтөлбөрөөр нэвтрүүлжээ. Гэтэл интернет сайтад тавигдсан бичлэгийг ердөө ганцхан цагийн дотор 1000 үзэгч үзсэн бол, KTVU-TV телевиз тэрхүү бичлэгийг өөрийн вебсайтад тавьсан эхний өдөр л гэхэд 40 000 хүн үзсэн болохыг мэдээлж байв. Болсон үйл явдлын тухай шууд хэлэлцүүлэг Америк даяар өрнөв.

Цагдаа нар болон Оакландын цагдаагийн хэлтсийн эсрэг олон түмний эсэргүүцэл нэн хурц, ширүүн байлаа. Олон түмний шахалтаар хэрэг шалгах ажиллагааг явуулсан боловч ээдрээтэй үр дүнд хүрэв. Цагдаагийн албан хаагчдад ял тулган, хариуцлага тооцоогүй байв. Ийнхүү ямар ч хариуцлагагүй хандсан нь олон түмний уур хилэнг дэвэргэж эсэргүүцлийн жагсаал, цуглааныг хэдэнтээ зохион байгуулав. Оскар Грантын эцэг эх хотын захиргааг шүүхэд мэдүүлэн 10 сая доллар нэхэмжлэв.

## Жишээ 2.

Ираны Ерөнхийлөгчийн сонгууль дэлхийн улс төрд дижитал мэдээллийн хэрэгслийн нөлөөг харуулсан хамгийн сүүлийн сонгодог жишээнд тооцогдож байна. Тус улсын 2009 оны Ерөнхийлөгчийн сонгууль нь ардчилсан сөрөг хүчнийхний эсрэг сонгуулийн дүнг хэрхэн мушгин гуйвуулж болохыг бодитой харуулсан. Ерөнхийлөгч Ахмадинежад саналын ихээхэн зөрүүтэйгээр сонгуульд ялалт байгуулан дахин сонгогдлоо хэмээн засгийн газраас мэдэгдсэн ч, эсэргүүцэгчид хэзээний гудамжинд гарчихсан жагсаал цуглаан зохион байгуулж байв. Цагдаа болон Хувьсгалт Хамгаалагчид эсэргүүцэгчид рүү улайран дайрах үед дэлхий даяар олон зуун видео бичлэгийг интернет сайтуудаар цацан засгийн газрын зүгээс явуулж буй үйл ажиллагааг дэлгэн харуулжээ. Хэд хэдэн видео бичлэг хүмүүсийг цохиж зодон, буудан хороож байгааг бичиж авсан байлаа.

Ийнхүү YouTube болон “Гэрч” зэрэг сайтуудад бичлэгүүдийг байрлуулж, улмаар хүний эрхийн төлөө тэмцэгчид Facebook ба Twitter зэрэг сайтууд дээр олон нийтийн мэдээллийн сүлжээг нээсэн нь Иранд өрнөсөн хэрэг явдлыг онцгой болгон харуулж чадсан. Facebook сайтыг анх Харвардын Их Сургуулийн оюутан тус сургуулийн оюутнуудын өөр хоорондоо онлайн харьцаж болох арга замыг эрэлхийлж нээсэн бол аажмаар энэ нь дэлхий даяар их сургуулийн оюутнуудыг багтаасан нээлттэй сүлжээ болж эцэст нь улс төрийн хавчлага шахалтын бодит дүр төрхийг нээн харуулсан Ираны оюутнууд болон

эсэргүүцлийн хөдөлгөөнийхний харилцах хэрэгсэл болсон юм. Энэ асуудалд харьцангуй сүүлийн үеийн бүтээл, олон нийтийн сүлжээний өөр нэгэн вебсайт болох Twitter-ийг мөн ашигласан. Энэхүү хоёр сайт хоёулаа олон хүнд мэдээлэл, зураг, дүрс бичлэгийг маш түргэн хугацаанд хүлээн авах боломж олгосон. Ираны эрх баригчид эдгээр сайтуудыг хаахаар оролдох үед АНУ болон Их Британи дах компьютерийн хакерууд дээрхи сайтуудыг нээхээр Ираны засгийн газрын вебсайтад хүртэл нэвтрэн орж байлаа.

Иранд өрнөсөн хэрэг явдлын эцсийн үр дүн тодорхойгүй хэвээр үлдсэн ч дарангуйлагч улс төрийн дэглэмийн үйл ажиллагаанд сануулга өгсөн коммуникацийн дижитал хэлбэрийн хүч чадлыг илтгэн харуулсан явдал болж чадсан. Ираны хэрэг явдал дижитал эрин дэх улс төрийн коммуникацийн ардчилсан байдал, түүний хүч, боломж бололцоог магадгүй бусдаас илүү харуулж өгсөн.

### **Улс төрийн сурталчилгаа:**

Улс төрийн кампанит ажил ердөө саяханыг хүртэл улс төрийн сурталчилгааг хяналтандаа барьдаг байлаа. Ерөнхийлөгч Рональд Рейганы хувийн зөвлөхүүд Пи Ар болон зар сурталчилгааны салбарын алдартай хүмүүс (мэргэжилтэнгүүд) байсан бол, Ерөнхийлөгч өөрөө Голливудын жүжигчин байв. Төрийн бодлогын асуудлаархи Ерөнхийлөгчийн бодит оролцооны түвшин маргаантай байдаг хэдий ч, хамгийн чухалд тооцогдох түүний нэгэн шинж бол мэдээллийг дамжуулах чадавхи гэдэгт эргэлзэх хүн үгүй бизээ. Рейган Ерөнхийлөгч Жон Кеннедийн “Шинэ чиглэлийн бодлого” ба Ерөнхийлөгч Линдон Жонсоны дэвшүүлсэн “Агуу их нийгэм” лоозон нь Америкийн эдийн засгийн чадавхи, ёс суртахууны үнэт зүйлсийг доройтуулсан явдал болсон гэсэн улс төрийн мессежийг илгээгээд, Америкийн нийгэм, улс төрийн амьдралд гүйцэтгэх засгийн газрын үүргийг эрс багасгах шаардлагатай хэмээн үзэж байв. Ерөнхийлөгч Рейган тухайн цаг үедээ хамгийн нарийн боловсрогдсон сурталчилгаа болон үр нөлөөтэй мэдээллээр дамжуулан БННамын орчин үеийн үзэл суртлын үндсийг тавьсан хэмээн тооцогддог. 1984 оны сонгуулийн кампанит ажилд зориулан бүтээсэн, Рейганы эдийн засгийн бодлогын амжилтын нотолгоо болгон харуулсан “Америкийн Өглөө” сурталчилгаа нь үүний нэгэн тод томруун жишээ. Уг сурталчилгааны хуудсын имиж болон Америкийн төрийн далбаа нь Америкчуудад Вьетнамын дайны синдром, Иргэний Эрхийн хөдөлгөөн болон 1970-аад оны эдийн засгийн хямрал хэдийн ард хоцорсон хэмээн харуулахыг зорьж байлаа.

Дижитал эринд янз бүрийн дүр төрхийн нийлмэл хэлбэр нь яг л тэс өөр цаг үед аваачсан мэт санагдуулах нь бий. 2004 онд Айова мужийн анхан шатны сонгуулийн кампанит ажлын үеэр ийм нэгэн явдал болов. Бүхий л талаараа ухаалаг, хэрсүү, нухацтай улс төрчид тооцогдох Ардчилсан Намын гишүүн Ховард Диин Ардчилсан Намынхнаас хамгийн анх Иракийн дайны асуудлыг сонгуулийн кампанит ажлынхаа үеэр хөндөж байсан бөгөөд эцэст нь сонгогчидтой хийх нэгэн уулзалтын үеэрээ хяналтаа алдан хашгирсан байна.

(Ялагдал хүлээсэндээ хэт бачууран, ялагдлаа нөхөхийн тулд дараачын муж руу “Явцгаая” хэмээн хашгирчээ. -Орч.) Түүний “Дииний хашгираан” гэх алдарт зураг тэр дорхноо тархаж, улмаар хилийн дээс ч алхаад амжжээ. Эхэндээ түүний хашгирсаныг бүжгийн аятай хэмнэл нийлүүлэн хоршуулсан бол удалгүй олон тооны өгүүллийн сэдэв болж, цаашлаад видео ремикст оруулж, эцэст нь Африк-Америк гаралтай хошин урлагийн жүжигчин Дэйв Чапель өөрийн алдарт ремиксийн төгсгөлийн хэсэгт оруулан инээдмийн шоу нэвтрүүлэгтээ ашиглажээ. Ховард Диин Ардчилсан Намын Даргын албыг хүртэл хашиж, “50 муж улс” гэгдэх 2008 оны сонгуульд зориулсан стратегийг боловсруулсан хэдий ч, хяналтаа алдан хашгирсан өөрийн имижээс хэзээ ч бүрэн ангижирч чадаагүй юм.

Хэдийгээр түүний тэрхүү хашгирах дуу нь улс төрийн сурталчилгаа байгаагүй ч, гэрлийн хурдаар тархах мэдээллийн хүч чадлыг үзүүлсэн явдал болсон. Ерөнхийлөгч Жорж Бушийн үед янз бүрийн видео ремиксүүд урьдын адил хэрэглэгдсээр байв. 2003 оны Ерөнхийлөгч Бушийн улс орны нөхцөл байдал, хэтийн төлөвийн тухай хэлэлцсэн илтгэлд “нүгэлт тэнхлэг”-ийн бодлогын тухай толилуулахдаа Иракт явуулах дайны ажиллагааны тухай дурдсан нь тоо томшгүй олон удаа Ерөнхийлөгчийн дайнч гаж хүсэл, хиймэл инээмсэглэлийг нь дэлгэн харуулж тайлбарлахыг оролдсон ремиксүүдэд ашиглагдахад хүрч байв.

2008 оны сонгуулийн үеэр телевиз радиогоос илүүтэй интернетийн YouTube сайтаас л хамгийн үр нөлөөтэй, олны анхааралд өртсөн сурталчилгааг олж үзэх боломжтой байв. Нэр дэвшигчдийн сурталчилгаа ихэвчлэн мартагддаг. Гэвч хамгийн ихээр анхаарал татсан сурталчилгааны материалд “Алдартан” гэгдэх, нэр дэвшигч Маккэйн сонгуулийн кампанийн үеэрээ өөрийн өрсөлдөгч Обамаг ердөө л нэг нэр төдий алдартан болгон харуулахыг оролдсон зураг орно. Энэ нь хэвлэлийнхний мэдээ, хэлэлцүүлгийн сэдэв болож чадсан ч, түүний тооцоолж байсанчлан сонгуулийн кампанит ажилд нь төдийлөн тус хүргэсэнгүй. Обамаг Харвардын Эрхзүйн Тойм (Harvard Law Review) сэтгүүлийн хуучин редактор, Үндсэн хуулийн эрхзүйн профессор байсан хэдий ч ердөө нэг хоосон толгой, хувцасны гол болгон харуулах гэсэн нь тийм ч хялбар борлох бараа болж чадсангүй. Гэхдээ нөгөө талаар, Обамагийн сонгуулийн кампанит ажил бүхэлдээ нэг хэвийн, сонирхолгүй, аль нь ч улс төрийн сурталчилгааны түүхэнд үлдэхээр бүтээл болж чадаагүй гэдгийг хэлэх хэрэгтэй.

2008 оны сонгуулийн улс төрийн сурталчилгааны жинхэнэ тулаан интернетийн YouTube сайтад өрнөж байсныг хэлэх хэрэгтэй. Нэр дэвшигч Хиллари Клинтон өөрийн сонгуулийн кампанит ажлыг хэдийгээр эцэстээ төдийлөн олигтой үнэлгээ авч чадаагүй ч, YouTube сайт дээр явуулахаар шийдсэнээ мэдэгдсэн. Хатагтай Клинтон мэдэгдэл нэлээдгүй буурь суурьтай намбалаг харагдах хэдий ч интертэтээс ер бусын, нэг үгээр хэлбэл хэвшмэл бус хэлбэрийг хүлээж байдаг үзэгчдэд огт таалагдаагүй юм. Ердөө л телевизээр

өгдөгтэй адил мэдээллийг интернетээр цацах нь төдийлөн олны сонирхлыг татаж чадахгүй.

Хамгийн мартагдашгүй сурталчилгаа нь Клинтоны эсрэг чиглэсэн “Өөрийг сонго” зар байв. Энэ нь 1984 онд Айпл (Apple) фирмээс Макинтош компьютерийг шинээр худалдаанд гаргах үедээ ашигласан сурталчилгааны материалын шууд хуулбар байсан юм. Тухайн үед уг фирм персонал компьютерийг телевизийн давамгайлах нөлөөг халах альтернатив хэлбэр хэмээн сурталчилж байсан нь телевизийн зар сурталчилгааны аажим мөхлийг урьдчилан таамагласнаараа нь эргэлзээгүйгээр телевизийн түүхэн дэх хамгийн мартагдашгүй, хамгийн сонирхолтой сурталчилгаа болсон. “Айпл” фирм тухайн үеийн сурталчилгааны материалдаа Жорж Орвеллийн “1984”<sup>20</sup> өгүүллийг ашиглан ремикс хийсэн. “Өөрийг сонго” сурталчилгаанд Хиллари Клинтонг нэлээдгүй хүйтэн, тооцоотой гэгддэг нэр хүндтэй нь харьцуулан “Том Ах”-ын дүрээр гаргасан. Хэдийгээр үүнийг Обамагийн сонгуулийн кампанийхан бүтээгээгүй боловч Клинтон руу дайрч буй эмэгтэй Обама маягийн богино цамц өмссөн харагдана. Сурталчилгааны материалын төгсгөлд Обамагийн сонгуулийн кампанийн эмблемийн ремикс дэлгэцэнд гарснаар дуусна.

Клинтоны сурталчилгаа нь улс төрийн сурталчилгааны төгсгөл ирснийг зарласаныг бид нэгэнт мэднэ. Энэ нь түүний кампанит ажлын эхэн үед нарийн засч сайжруулан, боловсруулсан байдлаар илэрч байв.

“Тиймээ, бид чадна” Энэ нь мөн л YouTube сайтад үзэгдэх болж Обамагийн илтгэлийг, янз бүрийн уран бүтээлчид, хөгжимчид хөгжмийн аялгуунд Обамагийн сонгуулийн кампанийн уриаг давтаж буйтай чадварлаг хослуулан найруулжээ. Уг бүтээлийг бүхэлд нь хар, цагаан өнгөөр бүтээсэн нь Обама Америкийн түүхийн янз бүрийн санаа бодол, үйл явдал, билэг тэмдгийг төлөөлж буйг харуулахыг оролджээ. Обама өөрийн илтгэлдээ ч түүхэн ач холбогдолтой тулгуур баримт бичгүүд, Геттсбургийн илтгэл болон Америкийн иргэний эрхийн хөдөлгөөнийхөний үг хэллэгээс шууд иш татсан байдаг. Энэхүү ремикст уран бүтээлчид ч мөн өөрийн дуу хоолой, өнгө төрхөөр хувь нэмрээ оруулсан нь гарцаагүй. Үүнийг нэгэнт телевизээр цацаагүй тул үзэгч сонсогчид анхаарлаа төвлөрүүлсэнээр агуулгыг нь ухаж ойлгох боломжтой болох ба ердөө гуравхан минут үргэлжлэх энэ бичлэг олон зуун хитийг тэргүүлж байв.

Гэхдээ вебсайт гэдэг эерэг, сөрөг сурталчилгааны талбар төдийгүй заримдаа бүр огтын сонирхолгүй байдал, хэрцгий балмад үйлдэлтэй хиллэх нь ч бий. Тухайлбал, нэр дэвшигч Маккэйныг YouTube сайт эцэс төгсгөлгүй оролдож байснаас хамгийн дуртай бай нь түүнд зориулсан “Эргийн залуус” хамтлагийн (Barbaran) дууг “Ираныг Бөмбөгд” болгон засварласан найруулга, Сара Палиныг Дэд Ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх болсон

---

<sup>20</sup> ( Жорж Орвеллийн 1948 онд бичсэн, тотатитари дэглэмийг хурцаар шүүмжлэн түүний хэтийн төлөв 1984 гэхэд хэрхэн өөрчлөгдсөн байх тухай таамаглал дэвшүүлсэн бүтээл. -орч)



Маккэйны шийдвэр болон түүний нас байлаа. Дахин засварласан хэдэн арван видео бичлэгүүдэд түүний насыг хошигнон даажигнаж байв.

2008 он гэхэд нэг л зүйл тодорхой болсон нь, улс төрийн кампанит ажлын мэдээллийн төвлөрсөн хяналт гээч зүйл цаашид үйлчлэхээ больж байгааг баттай харуулав. YouTube сайт нь сонгуулийн кампанит ажлын материалыг боловсруулах, нийтэд түгээх гол газар болжээ. Цаашлаад, кампанит ажлын үеэр гол гол муж улсууд дах “савлагаатай” сонгогчдод зориулсан сонгуулийн сурталчилгаа, мэдээлэлд анхаарлаа хандуулдаг хэдий ч, бусад газруудад орших “хасагдсан” сонгогчдод хүртэл тэдний мэдээллийг хүлээн авах боломжийг YouTube сайт тэнцвэртэй олгохын дээр, тэдгээр мэдээлэлд нөлөөлөх боломж ч бас нээлттэй байдаг.

Дижитал технологийн эрин дэлхийн улс төрийн сурталчилгааг бүхэлд нь өөрчлөхөд хүргэв. Ирээдүйд нэр дэвшихийг хүсэх хэн ч болов, хорин нэгдүгээр зууны дижитал амьдралын эдрээтэй олон хэлбэрүүдтэй хэл амаа ололцож байж л амжилтанд хүрнэ. Маккэйнээс ялгаатай нь Обама дижитал мэдээллийн хэрэгслийг үр нөлөөтэй ашиглах аргаа олсон байв. Энэ нь түүнийг дэмжигчдийн олонхи нь дижитал мэдээллийн хэрэгслийг жинхэнэ утгаар нь эзэмшигч залуус байсантай нь холбоотой. Залуусыг хөдөлгөнө гэдэг угтаа бол дижитал ертөнцийг хөдөлгөж байна гэсэн үг. Ирээдүйн сонгуулиар юу болохыг хэн ч таашгүй боловч биднийг гайхшруулсан гэнэтийн зүйлс гарна гэдэг эргэлзэхгүй байна.

## ДҮГНЭЛТ

Судлаач Роберт Райк үндэсний эдийн засгаас дэлхийн эдийн засаг руу шилжих шилжилтийн талаар маш их бичиж байсан. Өмнөх нь тушаал захирамж гарган, түүнийгээ хэрэгжүүлж байдаг шатлан захирах тогтолцоотой, сонгодог бюрократ бүтэц юм. Зүйрлүүлж авсан ч, бодит байдал дээр ч, энэ нь хорьдугаар зууны мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааны зарчимтай тохирч байдаг. Гэтэл, 1980-аад оноос хуучны, нүсэр том корпорациудын задрал эхэлсэн. Түүний дүнд АНУ-д л гэхэд “аж үйлдвэргүйжилт” гэгдэх тэрхүү нэр томъёо дүйхээр болсон. Хөрөнгө капитал өөрөө илүү хөдөлгөөнтэй, илүү бутрамхай шинжтэй болсоноор энэ нь Америкийн эргээс хальж хямд ажиллах хүчний байнгын эрэл хайгуулд мордсон.

АНУ-ын аж үйлдвэрийн салбарын уналт нь дэлхийн бусад хэсгүүд дэх аж үйлдвэржилтийн өсөлттэй нягт холбогдоно. Гэхдээ энд зөвхөн үйлдвэрлэлийн уналт, задралын тухай яриагүй. Тэдгээр үйлдвэрлэлийг эзэмшигчдийн бүтцэд ч өөрчлөлт орж эхэлснийг хэлэх нь зүйтэй. Дэлхийн эдийн засаг дээд зэргийн зохион байгуулалттай үндэсний шатлан захирах тогтолцооноос өөр хоорондоо нарийн нягт сүлжилдсэн эдийн засгийн компаниудын сүлжээ рүү шилжиж байна.

Дэлхийн эдийн засагт гарч буй энэ мэт олон өөрчлөлтүүд дижитал эдийн засгийн өсөлттэй нягт холбоотой. Эдийн засгийн амьдрал илүү сүлжээ маягийн,

гэхдээ бас илүү бодитой болж байна. Энэ нь ч улс төрийн коммуникацид онцгой чухал нөлөө үзүүлж байгааг дурдах нь зүйтэй. Эдийн засагт ч, дэлхийн улс төрд ч илүү олон шинэ орон зай нээгдэх болов. Тодорхой газарт орших хөрөнгийн хуримтлалтай нягт холбогдож байсан үндэстэн-улс хэмээх ойлголтын хувьд хөрөнгийн хэлбэрүүд үндэстний хил хязгаараас гарч буйгаараа уналт сүйрлийг дуудах шиг. Гэхдээ нэг талаар уналт доройтолд хүргэж байгаа ч нөгөө талаар хүч сорих өөр олон боломжийг бий болгож байна. Нэгэн цагт зөвхөн улс төрийн элитүүд болон менежерүүдийн үйл ажиллагааны талбар, үүрэг хариуцлагын хүрээнд багтаж байсан улс төрийн коммуникаци нь урьд өмнө таамаглаж ч байгаагүйгээр олон түмний гарт шилжих үйл явц эхлээд байна.

Өөрөөр хэлбэл, улс төр ба эдийн засаг нь коммуникацийн хэрэгслээр дамжуулан өөр хоорондоо нягт холбогддог болж байна. Урьд нь Нью Йорк, Москва гэх мэт цөөхөн тооны газруудад төвлөрч байсан улс төр ба эдийн засгийн засаглалын төвүүдийн тоо одоо Хятад болон Азийн бусад орнуудын эдийн засгийн өсөлттэй зэрэгцэн нэмэгдэх болов. Эдгээр эдийн засаг, улс төрийн тогтолцоонууд хэрхэн өөр хоорондоо уялдан хувьсахыг таахын аргагүй. Харин хуучин институтууд нь хорьдугаар зуунд байсан шигээ хөгжиж чадахгүй гэдэг нь нэгэнт тодорхой болжээ. Ирээдүйн засаглал нь дижитал улс төрийн коммуникацийн өргөн сүлжээгээр хэлбэршин (төлөвших) болно.

#### **Ашигласан ном зохиол**

Amazon Watch, <http://www.amazonwatch.org/>

Azimow, Michael, and Shannon Mader, *Law and Popular Culture: A Course Book*, 2004.

Badger, Anthony, *The New Deal: The Depression Years, 1933-1940*, 2007.

Bernays, Edward, *Propaganda*, 2004.

Brooke Singer, BSING, <http://www.bsing.net/blog/>

California Newsreel, <http://newsreel.org/>

Chahan, Michael, *The Politics of Documentary*, 2007.

Chomsky, Noam, *Media Control: The Spectacular Achievements of Propaganda*, 2003.

Dennis, Everette E. and Melvin L. DeFleur, *Understanding Media in the Digital Age*, 2009.

Giglio, Ernest D., *Here's Looking at You: Hollywood, Film, and Politics*, 2005.

Grudin, Robert, *American Vulgar: The Politics of Manipulation Versus the Culture of Awareness*, 2006.

Ellis, Jack E. and Betsy A. McLane, *A New History of Documentary Film*, 2009.

Facebook, <http://www.facebook.com/>

Fiske, John, *Understanding Popular Culture*, 1989.

Foster, Patrick, "Iran Election: State Moves to End 'Facebook Revolution,'" *Times Online*, June 14, 2009.

Habermas Jurgen and Thomas McCarthy, *The Theory of Communicative Action, Volume 1: Reason and Rationalization of Society*, 1985.

hooks, bell, *Outlaw Culture: Resisting Representations*, 2006.

Herman, Edward S. and Noam Chomsky, *Manufacturing Consent*, 2002.

Jamieson, Alexander, " Facebook Becomes Early Battleground in Iran Elections," *The Telegraph*, May 2009, <http://www.telegraph.co.uk/news/5317914/Facebook-becomes-early-battleground-in-iran-elections.html>

Jenkins, Henry, III, Tara McPherson, Jane Shattuc, and Elayne Rapping, *Hop on Pop: The Politics and Pleasures of Popular Culture*, 2003.

Johhson-Cartee, Karen S., *Strategic Political Communication: Rethinking Social Influence, Persuasion, and Propaganda*, 2003.

Leuchtenburg, William Edward, *Franklin D. Roosevelt and the New Deal*, 2009.

Lewis, Richard L., *Digital Media: An Introduction*, 2004.

Lilleker, Darren G., *Key Concepts in Political Communication*, 2006.

Lipschutz, Ronnie D., *Political Economy, Capitalism, and Popular Culture*, 2010.

Parr, Ben, *How To: Track the Iran Election with Twitter and Social Media*, *Mashable: The Social Media Guide*, <http://mashable.com/2009/06/14/new-media-iran/>

McLuhan, Marshall, *The Medium is the Message*, 2005.

McCluhan, Marshall, *Understanding Media: The Extensions of Man*, 2003.

McNair, Brian, *An Introduction to Political Communication*, 2007.

Nichols, Bill, *Introduction to Documentary*, 2001.

Nichols, Bill, *Representing Reality*, 1991

Humphreys, Lee and Paul Messaris, *Digital Media: Transformations in Human Communication*, 2006.

Pratkanis, Anthony, Elliot Aronson, *Age of Propaganda: The Everyday Use and Abuse of Persuasion*, 2001.

Pavlik, John V., Media in the Digital Age, 2008.

Pfetsch, Barbara, Comparing Political Communication: Theories, Cases, and Challenges, 2004.

Protest of Iran Election, Facebook, <http://www.facebook.com/group.php?gid=115210055140>

Rozell, Mark J. Media Power, Media Politics, 2003.

Shabo, Magedah, Techniques of Propaganda and Persuasion, 2008.

Strinati, Domini, An Introduction to Theories of Popular Culture, 2004.

Storey, John, Cultural Theory and Popular Culture: An Introduction, 2006.

Street, John, Politics and Popular Culture, 1997.

Superfund 364: A Site a Day, <http://superfund365.org/>

Tuman, Joseph S., Political Communication in American Politics Campaigns, 2007.

Turbulence, <http://www.turbulence.org/>

Twitter, <http://twitter.com/>

Witness, <http://www.witness.org/>

Wong, Yue-Ling, Digital Media Primer, 2008.

Zakin, Susan, Coyotes and Town Dogs: Earth First and the Environmental Movement, 2002.

### **Abstract**

The article looks at recent changes in how media is influencing aspects of political life. It distinguishes between the analog age of the twentieth century and the digital age of the twenty-first. During the analog age, media was expensive to produce, and, as a result, was produced by large private and public institutions, such as Hollywood (private) and the Nazi (government). Media tended thus to move from the top downward, and it was often used to shape and influence opinions. Hence, twentieth century media is often closely associated with political propaganda and advertising. In the twenty-first century, however, with the development of small, powerful computers, cell-phones, digital cameras, and the systems that make their distribution fast and cheap, virtually everyone is a potential producer and distributor of media. As a result, citizens around the world are using these technologies to challenge systems of political power. Examples are offered from the United States, Iran, and Burma to support the thesis that digital technology has had a major impact on the political world in various parts of the world.